

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ДУБНА ХОТ ДАХЬ
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН БАЙГУУЛЛАГА –
ЦӨМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ИНСТИТУТИЙН
ЗАХИРАЛ АКАДЕМИЧ В.А.МАТВЕЕВИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Виктор Анатольевич Матвеев 1941 оны 12 сарын 11-нд ЗХУ-ын (тэр үеийн нэрээр) Новосибирск мужийн Тайга хотод төржээ.

Боловсрол:

1959–1964 онд Алс дорнодын их сургуулийн физик-математикийн факультет, Ленинградын их сургуулийн Физикийн факультетэд суралцаж төгссөн.
1967 онд физик-математикийн ухааны дэд эрдэмтэн,
1973 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан.

Мэргэжлийн үйл ажиллагаа:

1965–1978 онд Дубна хот дахь Цөмийн Шинжилгээний Нэгдсэн Институтийн Онолын физикийн лабораторид эрдэм шинжилгээний дэд болон ахлах ажилтан, секторын эрхлэгч;
1976-1977 онд АНУ-ын Э.Фермийн нэрэмжит Үндэсний хурдасгагчийн лабораторид ЦШНИ-ийн физикчдийн ахлагч;
1978 оноос ОХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Цөмийн судалгааны институтийн орлогч захирал, 1987 оноос захирал;
2011 оны 9 сараас ОХУ-ын Дубна хот дахь олон улсын засгийн газар хоорондын байгууллага – Цөмийн Шинжилгээний Нэгдсэн Институт (ЦШНИ)-ийн захирал.

Сургалтын ажил:

1980–1992 онд Москвагийн УИС-ийн Физикийн факультетийн Квант статистик ба оронгийн онолын тэнхмийн профессор;
1992 оноос Москвагийн УИС-ийн Физикийн факультетийн Квант онол, их энергийн физикийн тэнхмийн профессор;
1995 оноос Москвагийн физик-техникийн институтийн Суурь харилцан үйлчлэл ба космологийн тэнхмийн эрхлэгч.

Шинжлэх ухааны удирдлагын үйл ажиллагаа:

- 1992 оноос ЦШНИ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн;
- 1992 оноос “Ядерная физика” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн;
- 1996-2000 онд Оросын суурь судалгааны сангийн зөвлөлийн гишүүн;
- 1996 оноос Европын цөмийн судалгааны байгууллага (ЦЕРН) -ын LHC хурдасгагч дээр хийх CMS туршилтад оролцогч ОХУ болон ЦШНИ-ийн гишүүн орнуудын эрдэмтдийн зөвлөлийн дарга;

- 1996 оноос Оросын ШУА-ийн тэргүүлэгчдийн газрын гишүүн бөгөөд Оросын ШУА-ийн Цөмийн физикийн салбарын эрдэмтэн нарийн бичгийн даргын орлогч;
- 1996 оноос Оросын ШУА-ийн Троицкийн эрдэм шинжилгээний төвийн тэргүүлэгчдийн газрын дарга;
- 1998 оноос Олон улсын цэвэр ба хэрэглээний физикийн холбооны “Астрофизик частиц и ядер, гравитация” хэмээх олон улсын хорооны гишүүн;
- 1999 оноос ОХУ-ын Эрдмийн зэрэг цол олгох дээд зөвлөлийн гишүүн;
- 2000 оноос Оросын ШУА-ийн “Нейтриногийн судалгаа” хэмээх суурь судалгааны хөтөлбөрийн удирдагч;
- 2008 оноос Оросын ШУА-ийн физикийн салбарын эрдэмтэн нарийн бичгийн дарга;
- 2011 оноос ЦШНИ-ийн Эрдмийн зөвлөлийн дарга.

Эрдэм шинжилгээний ажлын чиглэл:

Академич В.А.Матвеев нь квант оронгийн онолын аргыг хөгжүүлэх, адроны релятив кваркан загвар боловсруулах, өндөр энергийн үед явагдах процессын динамикийг судлах, цөмийн кваркан онол бүтээх, атомын цөм дэх кваркийн чөлөөний зэргийг илрүүлэх, тохируулгат онол дахь вакуумын бүтцийг судлах болон түүнтэй холбоотой туршлагаар илрэх үзэгдлүүдийг судлах талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдөж нэрд гарсан эрдэмтэн юм.

Эрдэм шинжилгээний бүтээл:

Эрдэм шинжилгээний 300 гаруй бүтээл хэвлүүлсэн. “Өндөр энергитэй адроны их өнцгөөр уян харимхай сарних зүй тогтол буюу Матвеев-Мурадян-Тавхелидзе нарын кваркан тооллын дүрэм” хэмээх хамтын бүтээл нь нээлтээр бүртгэгджээ.

Хүндэт цол, шагнал:

- 1973, 1988 онд Лениний комсомолын шагнал;
- 1980 онд Москвагийн УИС-ийн профессор;
- 1991 онд Москвагийн УИС-ийн гавьяат профессор;
- 1991 онд Оросын ШУА-ийн сурвалжлагч гишүүн;
- 1994 онд Оросын ШУА-ийн жинхэнэ гишүүн;
- 1998 онд ОХУ-ын Төрийн шагнал;
- 1999 онд “Москва мужийн шинжлэх ухаан техникийн гавьяат зүтгэлтэн” цол;
- 1999 онд ОХУ-ын хүндэтгэлийн одон;
- 2000 онд ОХУ-ын засгийн газрын шагнал;
- 2000 онд Москвагийн УИС-ийн хүндэт профессор;
- 2007 онд ОХУ-ын Эх орны өмнө гавьяа байгуулсны IV зэргийн одон;
мөн Москва муж, Троицк хотын шагналуудаар шагнуулсан байна.

ЦШНИ-ийн удирдлага, олон улсын хамтын ажиллагааны хөгжилд оруулж буй хувь нэмэр:

Академич В.А.Матвеев ЦШНИ-ийн захирлын хариуцлагатай албанд томилогдсоноос хойш тус институтийн судалгааны суурь төхөөрөмжийг шинэчлэх, институтийн нэгдмэл байдлыг хадгалж олон улсад эзлэх байр суурийг өргөх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санаачлагатай ажиллаж, эрдмийн хамт олны талархлыг хүлээж байгаа юм. Сүүлийн жилүүдэд хэт хүнд химийн элементүүдийг ЦШНИ-ийн хурдасгагч дээр синтезлэн гаргаж авах, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Хиггс бозоныг нээх, нейтриногийн осцилляцийн шинэ хэлбэрийг ажиглах зэрэг материйн бүтцийн нууцыг тайлахад ЦШНИ-ийн эрдэмтдийн оролцоо чухал байсан нь тус институтийн удирдлагын үйл ажиллагаатай салшгүй холбоотой билээ.

Виктор Анатольевич Матвеев ЦШНИ-ийн захирлын хувьд гишүүн орнуудын ашиг сонирхлыг институтийн чиглэл зорилготой уялдуулах, түүний дотор Монгол улсын эрдэмтэд, цөмийн салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааг байнга дэмжиж байдаг.

Дубна хот дахь ЦШНИ-ийг Монгол Улс хамтран байгуулалцаж, хамтран ажиллаж ирсний дүнд манай улсад цөмийн физик хөгжих, цөмийн технологийг нэвтрүүлэх, нутагшуулах, өөриймшүүлэх үндэс суурь тавигдсан төдийгүй манай улсын шинжлэх ухааны сэтгэлгээний хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Энэ талаар зарим тоо баримт дурдвал: ЦШНИ-ийн тусламжаар МУИС, ШУА-д цөмийн физикийн судалгаа, компьютерийн чиглэлийн хэд хэдэн лаборатори байгуулсан; өнгөрсөн хугацаанд ЦШНИ-д давхардсан тоогоор манай 100 орчим мэргэжилтэн урт хугацааны томилолтоор ажиллаж, туршлагын болон онолын цөмийн физик, эгэл бөөмийн физик, программчлал, электроник, тооцон бодох математик, материал судлал зэрэг чиглэлээр мэргэшиж; 50 гаруй хүн эрдмийн зэрэг хамгаалсан байна. 2016 оны байдлаар ЦШНИ-ийн судалгааны 16 сэдэвт ажилд Монгол Улсын эрдэм шинжилгээний 7 байгууллага (давхардсан тоогоор 23 байгууллагын 50 орчим судлаач) оролцож байгаа ба урт хугацааны томилолтоор 9 эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байгаагийн зэрэгцээ жилд 10 хүртэл хүн 3 сарын, арав гаруй хүн 1-2 долоо хоногийн томилолтоор ЦШНИ-д ажиллаж байна.